



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот


**Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг  
сонгон шалгаруулах журам батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.4.1, 24.4.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг нэгдүгээр, “Нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварыг хоёрдугаар, “Ажлын хэсгийн гишүүний баталгаа”-ны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Б.БАТТӨМӨР

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга  
хариуцлагын байнгын хорооны 2023 оны  
05 тогтоолын нэгдүгээр хавсралт

## ЁС ЗҮЙН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.5 дахь хэсэгт заасны дагуу Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг сонгон шалгаруулах, томилуулахаар Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүний сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарсан тоогоор зарлаж, энэ журмын дагуу нэр дэвшүүлнэ.

1.3.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална:

- 1.3.1.хууль дээдлэх;
- 1.3.2.шударга ёсыг баримтлах;
- 1.3.3.аливаа нөлөөллөөс ангид байх;
- 1.3.4.ил тод байх;
- 1.3.5.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

1.4.Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1.“Орон тооны бус гишүүн” гэж Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг;

1.4.2.“Хүсэлт гаргагч” гэж Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргасан иргэнийг;

1.4.3.“Нэр дэвшигч” гэж энэ журмын 8.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэсэн иргэнийг.

1.5.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүний сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй Ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ ажиллана.

1.6.Ажлын хэсгийн ажиллах нөхцөлийг Байнгын хороо хангах бөгөөд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ. Энэ журамд заасны дагуу холбогдох баримт бичиг, зар, бусад мэдээллийг цахим хуудаст байршуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, нийтэд мэдээлэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

1.7.Ажлын хэсэг энэ журмын 1.3-т заасан зарчмыг баримталж, ажиллах журам болон хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

1.8.Энэ журмыг Улсын Их Хурлын цахим хуудас /www.parliament.mn/-д байршуулна.

### **Хоёр.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлага**

2.1.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг нэр дэвшүүлнэ. Үүнд:

2.1.1.ёс суртахууны манлайлал үзүүлэхүйц, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий иргэн гэдгээ ажил, мэргэжлийн үйл ажиллагаагаар нотлон харуулсан байх;

2.1.2.нэр дэвшигч нь 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, төрийн болон төрийн бус байгууллагын удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.3.боловсрол, хүмүүнлэг, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, менежмент ба удирдахуй, эрх зүйн мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх; /Мэргэжлийн чиглэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын баталсан мэргэжлийн чиглэл, индексийн дагуу ойлгоно./

2.1.4.нэр дэвших үедээ улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалд ажиллахгүй байгаа;

2.1.5.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;

2.1.6.ёс зүйн болон сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй байх;

2.1.7.сэтгэцийн өвчин, эмгэггүй байх;

2.1.8.Ёс зүйн хорооны бусад гишүүнтэй нэг анги хамт төгссөн, эсхүл хамаарал бүхий этгээд биш байх. /Төрийн албаны тухай хуульд заасны дагуу "нэг анги хамт төгссөн" гэснийг ерөнхий боловсролын дунд сургууль, их, дээд сургууль, коллежид нэг ангид хамт суралцаж төгссөнийг хамруулан ойлгоно./

### **Гурав.Сонгон шалгаруулалтын үе шат**

3.1.Сонгон шалгаруулалтыг дараах үе шатаар зохион байгуулна:

3.1.1.сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх;

3.1.2.ажлын хэсэг байгуулах;

3.1.3.нэр дэвших тухай хүсэлт гаргах;

3.1.4.нэр дэвшигчээр бүртгэх;

3.1.5.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, баримт бичиг судлах;

3.1.6.ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах;

3.1.7.нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгох.

### **Дөрөв.Сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх**

4.1.Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан зард нэр дэвших тухай хүсэлт гаргах хугацаа, баримт бичиг хүлээн авах хаяг, цахим шуудангийн хаяг, лавлах утасны дугаар, энэ журмын 2.1-д заасны дагуу Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавих шаардлага, энэ журмын 7.1-д заасны дагуу бүрдүүлэх баримт бичгийг заана.

## **Тав.Ажлын хэсэг байгуулах**

5.1.Ажлын хэсэг нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

5.2.Байнгын хороо дараах байгууллагаас санал болгосон албан тушаалтныг Ажлын хэсгийн гишүүнээр томилно:

5.2.1.Байнгын хорооноос томилсон Улсын Их Хурлын гурван гишүүн;

5.2.2.Байнгын хорооны ажлын албанаас санал болгосон нэг төлөөлөл;

5.2.3.Монгол Улсын Засгийн газраас санал болгосон нэг төлөөлөл;

5.2.4.Авлигатай тэмцэх газраас санал болгосон нэг төлөөлөл;

5.2.5.Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс санал болгосон нэг төлөөлөл;

5.2.6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссоос санал болгосон нэг төлөөлөл;

5.2.7.Монголын хуульчдын холбооноос санал болгосон нэг төлөөлөл.

5.3.Энэ журмын 5.2.1-д заасны дагуу томилогдсон Улсын Их Хурлын гишүүний нэгийг Байнгын хороо Ажлын хэсгийн ахлагчаар томилно. Ажлын хэсгийн ахлагч нь сонгон шалгаруулалтын бэлтгэлийг хангаж зохион байгуулах, хуралдааныг даргалах бөгөөд энэ журамд өөрөөр заагаагүй бол Ажлын хэсгийн гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.4.Ажлын хэсгийн гишүүнд санал болгосон төлөөллийг Байнгын хорооны хуралдаанаар нэг бүрчлэн хэлэлцэж, тогтоол гаргана. Ажлын хэсгийн гишүүнд санал болгосон хүн нь мэдлэг, туршлага, ёс зүйн хувьд шаардлага хангахгүй гэж үзсэн тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар санал болгох эрх бүхий байгууллагад дахин хандаж болно.

5.5.Энэ журмын 5.4-т заасан тогтоол гарсан даруйд Байнгын хорооны ажлын алба Ажлын хэсгийн гишүүдэд Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг танилцуулж, шаардлагатай мэдээллээр хангана.

5.6.Ажлын хэсгийн гишүүн нь Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах явцад энэ журмын 1.3-т заасан зарчмыг баримтална.

### **Зургаа.Ажлын хэсгийн чиг үүрэг, хориглох зүйл**

6.1.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1.1.нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авах, хянах;

6.1.2.хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэх;

6.1.3.нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, нэмэлт тодруулга авах;

6.1.4.нэр дэвшигч холбогдох шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ өгөх;

6.1.5.бүртгэл, сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг эцэслэн шийдвэрлэх;

6.1.6.сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан гэж үзсэн нэр дэвшигчийг томилуулах саналыг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасан тоог баримтлан Байнгын хороонд хүргүүлэх;

6.1.7.сонгон шалгаруулалтын үйл явц, дүнг нийтэд мэдээлэх;

6.1.8.сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын архивд хүлээлгэн өгөх.

6.2.Ажлын хэсгийн гишүүнд дараах үйл ажиллагааг хориглоно:

6.2.1.нэр дэвшигчтэй хамаарал бүхий этгээд байх;

6.2.2.Ажлын хэсгийн гишүүний үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглах;

6.2.3.хүсэлт гаргагч, нэр дэвшигчийг ялгаварлан гадуурхах;

6.2.4.сонгон шалгаруулалтад итгэх итгэлийг унагаж зохисгүй, ёс суртахуунгүй байдал гаргах;

6.2.5.Ажлыг хэсгийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг, шан харамж авах;

6.2.6.Ажлын хэсгийн гишүүний хувиар нэр дэвшигч нарын талаар урьдчилан дүгнэлт хийж, бусдад мэдээлэх;

6.2.7.Ажлын хэсгийн гишүүний нэр хүндийг урвуулан ашиглах.

6.3.Ажлын хэсгийн гишүүнд энэ журмын 6.2.1-д заасан нөхцөл үүссэн бол сонгон шалгаруулах ажиллагаанаас татгалзан гарна.

6.4.Ажлын хэсгийн гишүүн нь холбогдох хууль болон энэ журамд заасан чиг үүрэг, хориглосон зохицуулалтыг биелүүлэх талаар энэ журмын гуравдугаар хавсралтад заасан баталгааг гаргаж, Байнгын хороонд хүлээлгэж өгнө.

6.5.Ажлын хэсгийн гишүүний энэ журамд заасан зохицуулалтыг зөрчсөн үйлдэл нь тогтоогдсон тохиолдолд зөрчлийн шинж байдлыг харгалзан Ажлын хэсгийн гишүүнээс хасах, түүнд эрх бүхий албан тушаалтны зүгээс хуулийн дагуу хариуцлага тооцох саналыг хүргүүлэх зэрэг арга хэмжээг авахыг олонхын саналыг үндэслэн Ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэнэ.

6.6.Ажлын хэсгийн хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцож, гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

### **Долоо.Нэр дэвших тухай хүсэлт гаргах**

7.1.Энэ журамд заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 10 хоногийн дотор Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавих шаардлагыг хангасан иргэн дараах баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлэх бөгөөд уг хугацаа дууссанаас хойш баримт бичгийг хүлээж авахгүй.

7.1.1.нэр дэвших тухай хүсэлт;

7.1.2.Төрийн албан хаагчийн анкет “А” хэсэгт заасан мэдээлэл. /Маягт 1-ийн дагуу/;

7.1.3.иргэний үнэмлэхийн лавлагаа;

7.1.4.эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;

7.1.5.сэтгэцийн өвчин, эмгэггүй эсэхийг тодорхойлсон эрүүл мэндийн байгууллагын магадалгаа;

7.1.6.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;

7.1.7.боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/. Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;

7.1.8.цээж зураг;

7.1.9.ёс суртахууны манлайлал үзүүлэхүйц, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий иргэн гэдгийг нотлон харуулсан үйл ажиллагааны талаарх баримт, хүсэлт гаргагчийн талаарх тодорхойлолт.

7.2.Энэ журмын 7.1.1-д заасан нэр дэвших тухай хүсэлтийг энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан загварын дагуу бичиж, холбогдох бүх мэдээллийг үнэн зөв, бүрэн өгнө.

7.3.Энэ журмын 7.1.9-д заасан тодорхойлолтыг 3 доошгүй хүнээс авч хавсаргана. Тодорхойлогч нь хүсэлт гаргагчийн одоогийн, эсхүл өмнөх ажлын байрны шууд удирдах албан тушаалтан, эсхүл энэ журмын 2.1-т заасан шаардлага хангасан эсэх тухай бодит мэдээлэл өгөх боломжтой бусад хүн байна.

7.4.Энэ журмын 7.3-т заасан тодорхойлолтод хүсэлт гаргагчийг Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнээр ажиллахад тохирсон эсэх, энэ журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан эсэх, ажил хэргийн харилцааны талаар үнэн зөв тусгаж, тодорхойлогчийн нэр, эрхэлж байгаа ажил, ажлын газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаягийг бичиж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

7.5.Байнгын хорооны ажлын алба нь нэр дэвших тухай хүсэлт, түүний хавсралт, бичиг баримтын үнэн зөв байдлыг шалгах зорилгоор хавсаргасан материалын эх хувьтай нь тулгаж үзэж болно.

### **Найм.Нэр дэвшигчээр бүртгэх**

8.1.Бүртгэл хааснаас хойш ажлын 5 өдрийн дотор нэр дэвших тухай хүсэлт, холбогдох баримтыг Ажлын хэсэг хуралдаанаараа хянан хэлэлцэж, сонгон шалгаруулалтад нэр дэвшигчээр бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

8.2.Доор дурдсан тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана:

8.2.1.энэ журмын 7.1-д заасан баримт бичгийн бүрдүүлбэрийг хангаагүй;

8.2.2.энэ журмын 7.1-д заасан хугацаанд нэр дэвших тухай хүсэлт гаргаагүй.

8.3.Энэ журмын 8.2-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгээгүй бол энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр /шуудан, цахим шуудан, үүрэн холбооны хэрэгсэл ашиглаж/, эсхүл түүний зөвшөөрснөөр амаар мэдэгдэж тэмдэглэл үйлдэнэ. Хүсэлт гаргагч өөрийг нь нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан үндэслэлийг бичгээр өгөхийг шаардах эрхтэй бөгөөд Ажлын хэсэг энэ тухай тайлбарыг өгнө.

8.4.Хүсэлт гаргагч нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг энэ журмын 8.3-т заасны дагуу мэдсэнээс хойш ажлын хоёр өдрийн дотор Ажлын хэсэгт гомдол гаргаж болно.

8.5.Энэ журмын 8.4-т заасны дагуу хүсэлт гаргагч гомдол гаргасан бол Ажлын хэсэг ажлын таван өдрийн дотор хуралдаж, гомдлыг эцэслэн шийдвэрлэх бөгөөд энэхүү шийдвэрт гомдол гаргахгүй.

8.6.Энэ журмын 8.2-т заасны дагуу нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсаны улмаас Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэг ч нэр дэвшигч бүртгэгдээгүй бол Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг дахин явуулах тухай саналыг Байнгын хороонд гаргаж болно.

### **Ес.Нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, баримт бичиг судлах**

9.1.Энэ журмын 8.1-д заасны дагуу бүртгэсэн шийдвэр гармагц Ажлын хэсэг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигчийн талаар дараах мэдээллийг цуглуулж, баримт бичгийг судална:

9.1.1.энэ журмын 7.1-д заасны дагуу ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг судлах, үнэн зөвийг нягтлах;

9.1.2.ажлын туршлага, үйл ажиллагааг судлах;

9.1.3.энэхүү журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баримт, мэдээлэл гаргуулах авах, ярилцлага хийх;

9.1.4.нэр дэвшигчтэй ярилцлага хийх, түүнээс нэмэлт мэдээлэл, баримт бичиг гаргуулах авах;

9.1.5.нэр дэвшигчийн талаар үнэлгээ өгөхөд зайлшгүй шаардлагатай мэдээллийг бусад хэлбэрээр цуглуулах.

9.2.Нэр дэвшигчийн талаар цуглуулсан мэдээлэлд сөрөг агуулга байвал нэр дэвшигчид танилцуулж, тайлбар өгөх боломжоор хангах бөгөөд мэдээллийн эх сурвалжийн нууцлалыг хадгална.

9.3.Ажлын хэсэг нэр дэвшигчийн талаарх мэдээллийг цуглуулж, баримт бичгийг судалж, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлага тус бүрийг хангасан эсэх талаар үнэлгээ өгнө.

### **Арав.Ажлын хэсгийн ярилцлага зохион байгуулах**

10.1.Нэр дэвшигч энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг тодруулах зорилгоор Ажлын хэсэг ажлын 3 өдөрт багтаан нэр дэвшигч тус бүртэй ярилцлага зохион байгуулна.

10.2.Ажлын хэсэг зургаагаас доошгүй гишүүний ирцтэйгээр ярилцлага хийх бөгөөд Ажлын хэсгийн ахлагч даргална.

10.3.Нэр дэвшигч ярилцлагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол бүртгэлээс хасах үндэслэл болно.

10.4.Ажлын хэсгийн гишүүд ярилцлагын үеэр энэ журмын 2.1-д заасан шаардлагад үндэслэсэн асуултыг нэр дэвшигчээс асууж, хариулт авна. Ялгаварлан гадуурхсан, доромжилсон асуулт асуухыг хориглоно.

### **Арван нэг.Нэр дэвшигчийг Байнгын хороонд санал болгох**

11.1.Ажлын хэсэг ярилцлага хийж дууссанаас хойш 5 өдрийн дотор хуралдаж, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

11.2.Нэр дэвшүүлэх тухай хүсэлт, энэ журмын 9.3-т заасан үнэлгээ, Ажлын хэсгийн ярилцлагын дүнд үндэслэн Ажлын хэсгийн гишүүн санал хураалтад оролцоно. Ажлын хэсэг нэр дэвшигчийг үнэлэхэд нотолгоогүй мэдээллийг ашиглахгүй.

11.3.Ажлын хэсгийн гишүүн тус бүр Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавигдах шаардлага тус бүрийг хамгийн сайн хангасан гэж дүгнэсэн нэр дэвшигчийн талаар саналаа өгнө.

11.4.Нэр дэвшигчийг тодруулах санал хураалт явуулахдаа дараах журмыг баримтална:

11.4.1.Ажлын хэсгийн гишүүн бүр нэр дэвшигч тус бүрээр дэмжинэ эсхүл дэмжихгүй санал өгнө;

11.4.2.Санал хураалтыг нууцаар явуулна.

11.5.Санал хураалтын дүнгээр Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд нэр дэвшүүлнэ.  
*/"сул орон тоогоор"-гэснийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан Ёс зүйн хорооны орон тооны бус 4 гишүүний сул орон тоонд хамааруулан ойлгох бөгөөд цаашид хорооны орон тооны бус гишүүний сул гарсан орон тоонд энэхүү журамд заасан зарчмыг баримтлан сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна./*

11.6.Энэ журмын 11.5-д заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайланг дараах агуулгаар бэлтгэж, хуралдаанд оролцсон Ажлын хэсгийн гишүүд гарын үсэг зурна.

11.6.1.нэр дэвшигчийн товч танилцуулга;

11.6.2.сонгон шалгаруулалт, түүний үе шат хэрхэн явагдсан тухай;

11.6.3.нэр дэвшигч нь энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хэрхэн хангаж Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүн болоход хамгийн сайн тохирно гэж үнэлсэн үндэслэл.

11.7.Энэ журмын 11.6-д заасан мэдээллийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн бэлтгэнэ.

11.8.Энэ журмын 11.1-д заасан хуралдаанаас хойш, ажлын 5 өдрийн дотор энэ журамд заасны дагуу олонхын санал авсан нэр дэвшигчийн талаарх Ажлын хэсгийн тайлан, холбогдох баримт бичгийг Байнгын хороонд хүргүүлнэ.

11.9.Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хуралдаанаар олонх дэмжээгүй нэр дэвшигчийн сул орон тоонд Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийн эрэмбэлсэн дарааллаар нөхөн нэр дэвшүүлнэ.

11.10.Энэ журамд заасны дагуу санал хураалтаар Ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал аваагүй эсхүл Байнгын хорооны хуралдаанаар олонх дэмжээгүй бөгөөд онооны дарааллаар олонхын санал авсан нэр дэвшигч байхгүй тохиолдолд



тухайн сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг нийтэд дахин мэдээлэх саналыг Байнгын хороонд хүргүүлнэ.

11.11.Ажлын хэсгийн хуралдаан, түүний тэмдэглэл нь албаны нууцад хамаарах бөгөөд холбогдох хууль тогтоомжоор хамгаалагдана.

---ooOoo---

Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга  
хариуцлагын байнгын хорооны 2023 оны  
05 тогтоолын хоёрдугаар хавсралт

### НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэ загварт заасан асуулт, холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн бичиж, гарын үсэг зурж баталгаажуулан цаасан болон цахимаар Байнгын хороонд хүргүүлнэ.

Д/д	Нэг.Хүсэлт гаргагчийн товч танилцуулга
1	Эцэг, эхийн нэр Ургийн овог Нэр Хүйс Төрсөн он Төрсөн газар Оршин суугаа хаяг
2	Иргэний харьяалал
3	Ёс суртахууны манлайлал үзүүлэхүйц, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий иргэн гэдгээ ажил, мэргэжлийн үйл ажиллагаагаар нотлон харуулсан талаарх мэдээлэл.
4	Нэр дэвшигч нь 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай, төрийн болон төрийн бус байгууллагын удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан талаарх мэдээлэл.
5	Боловсрол, хүмүүнлэг, нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, менежмент ба удирдахуй, эрх зүйн мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн талаарх мэдээлэл. /Мэргэжлийн чиглэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын баталсан мэргэжлийн чиглэл, индексийн дагуу ойлгоно./
6	Нэр дэвших үедээ улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаалд ажиллахгүй байгаа талаарх мэдээлэл.
7	Ёс зүйн болон сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй талаарх мэдээлэл.

<b>Хоёр. Хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар</b>	
1	Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. /тайлбарыг 500-1000 үгэнд багтаана/
<b>Гурав.Мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга</b>	
1	Боловсрол
2	Мэргэжлээрээ ажилласан байдал
3	Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар
4	Байгаа бол хэвлүүлсэн бүтээл, олон нийтэд өгсөн мэдээлэл

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 7.1-д заасан бүрдүүлэх баримт бичгийг хавсаргах

**Хүсэлт гаргагч:**


Эцэг, эхийн нэр: .....

Өөрийн нэр: .....

Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: .....

---ooOoo---



Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 2023 оны 05 тогтоолын гуравдугаар хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮНИЙ БАТАЛГАА**

Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүн

.....  
/эцэг, эхийн нэр, өөрийн нэр/ миний бие Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг сонгон шалгаруулж, Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд нэр дэвшүүлэхийн төлөө өөрийн мэдлэг, чадвар, туршлагаа дайчлан, ёс зүйн өндөр шаардлагыг ханган чармайн ажиллахаа Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд үүгээр баталж байна.

Ажлын хэсгийн гишүүн би Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журамд захирагдан ажиллах болно.

Холбогдох хууль тогтоомж, журам, баримт бичгийг сайтар уншиж судлах бөгөөд Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 1.3-т заасан дараах зарчмыг чанд баримтална.

- 1.Хууль дээдлэх;
- 2.Шударга ёсыг баримтлах;
- 3.Аливаа нөлөөллөөс ангид байх;
- 4.Ил тод байх,
- 5.Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

Ажлын хэсгийн гишүүн би Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг уншиж судалсан бөгөөд түүнд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчихгүй, хэрэгжүүлж ажиллана.

Ажлын хэсгийн гишүүний хувьд дээр дурдсан зарчим, үүрэг, хориглолтыг сахин биелүүлж, түнийг зөрчвөл холбогдох хууль, журамд заасан хариуцлага хүлээнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, Ёс зүйн хорооны орон тооны бус гишүүнийг сонгон шалгаруулах журмын 6.4-т заасны дагуу энэхүү баталгааг гаргаж байна.

**Ажлын хэсгийн гишүүн:**

Эцэг, эхийн нэр: .....

Өөрийн нэр: .....

Гарын үсэг: .....

Он, сар, өдөр: .....